



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
АРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/113

Мандал

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Бэлбулаг багийн давааны ард худаг засварлах ажилд хяналт тавих, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Түвшинбаяр (Тархвар зүйч)
Гишүүдэд: Н.Балжинням (Хүнс худалдаа үйлчилгээ, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)
П.Одонцэнгэл (3-р багийн засаг дарга)

2.Бэлбулаг багийн давааны ард худаг засварлах ажлыг хүлээн аван, акт үйлдэн, чанартай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (С.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА

